

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ “2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ” –НИЙ 2021-2022 ОНЫ БИЕЛЭЛТ**

№	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Санхүүг ийн эх үүсвэр	Биелэлт
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ НЭГ. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ						
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: Нэг. Бодлого төлөвлөх, тодорхойлох						
Зорилт 1.Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.						
1.1.	Хууль хоорондын уялдааг нэгдсэн бодлогоор хангах зорилгоор нийтлэг харилцааг зохицуулсан хуулийн төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	Хамтран боловсруулсан хуулийн төслийн тоо	0	2	Улсын төсөв Бусад эх үүсвэр	Төрийн захиргааны төв болон захиргааны 17 байгууллагатай хамтран нийтлэг харилцааг зохицуулсан нийт 56 хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Мөн хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан холбогдох ажлын хэсгээс мэргэжил, арга зүйн туслалцааг тухай бүр өгч, хамтран ажилласан.
1.2.	Хууль зүйн бодлогын судалгаа хийх, хуулийн хэрэгжилтийг үнэлэх.	Судалгааны болон үнэлгээний тайлан	0	1	Улсын төсөв	Жагсаал цуглааны хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулын төслүүдэд Хууль зүй үндэсний хүрээлэн болон өөр байгууллагаар хууль төсөл боловсруулахад шаардлагатай тандан судалгаа, хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөө, зардлын тооцооны судалгаануудыг хийлгүүлсэн.
1.3.	Хууль сурталчлах, нэмэгдүүлэх. тогтоомжийг хүртээмжийг	Иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг тухай бүр нь	0	1	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн яамны 2022 оны хэвлэл мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 02 дугаар сарын 07-ны

		сурталчилсан эсэх				өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.Тухайлбал, 2022 оны 03 дугаар сарын 17, 24, 2022 оны 08 дугаар сарын 14, 2022 оны 10 дугаар сарын 28, 31 ний өдрүүдэд зохион байгуулагдсан хэлэлцүүлэг, уулзалт, арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 230 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг урьж оролцуулан, мэдээ сурвалжлага бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулсан. Мөн хуулийн төслийн танилцуулах хэлэлцүүлгийг олон нийтэд сурталчлахтай холбогдуулан ГХУСАЗЗАА-тай хамтран 14 төрлийн постерийг бэлтгэж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын болон яамны пэйж хуудаст, мөн Сэтгүүлчдийн нэгдсэн груп, Өнөөдөр болох үйл явдал зэрэг пэйж хуудаст тус тус байршуулж, мэдээллийг тухай бүрт хүргэж ажилласан.
1.4.	Захиргааны хэм хэмжээний актын бүртгэл хяналтын тайлангийн цахим системийг боловсруулах	Цахим сантай болсон эсэх	0	1	Улсын төсөв	Мэдээлэл, технологийн газрын боловсруулж буй программ дуусаагүй, мөн түүвэрлэн бэлтгэсэн мэдээллийг системд байршуулах ажил хийгдэж байгаа тул Захиргааны хэм хэмжээний актын бүртгэл, хяналт, тайлангийн системийг боловсруулах ажил түр хугацаагаар хойшлогдоод байна. “Хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын системчлэл, арга зүй, тогтолцоо болон эрх зүйн актын ангилагчийг шинэчлэн батлах” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд хууль хоорондын болон хууль, захиргааны хэм хэмжээний актын хоорондын уялдаа холбоог тогтоох, хуулийн эрх шилжүүлсэн заалт, захиргааны хэм хэмжээний актын үндэслэл болсон хуулийг бүртгэж тэмдэглэх, лавлагаа мэдээллийн санг бүрдүүлэх арга зүйг боловсруулж байна.
1.5.	Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын	Хуулийн шинэчилсэн найруулгын	0	5		Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/72 дугаар тушаалаар Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг

	хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх			Улсын төсөв	боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан бөгөөд хуулийн төслийг боловсруулж байна.
1.6.	Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, бизнес эрхлэх таатай орчныг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Анхдагч хуулийн төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	11	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар эцэслэн баталсан.
1.7.	Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.	Анхдагч хуулийн төсөл, хуулийн шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	2	Улсын төсөв	Хуулийн төслийг боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн.
1.8.	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгох замаар эрх зүйн орчныг сайжруулах	Хуулийн шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн	0	8	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.

		төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				
1.9.	Үндсэн хуулийн цэц болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	2	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын болон гадаад улс, орнуудын харьцуулсан судалгаа, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн. Улсын Их Хурлаас хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсантай холбогдуулан ХЗДХЯ-наас Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, хуулийн төслийг боловсруулж байна.
1.10.	“Эрх зүйн шинэтгэл II” хөтөлбөрийг боловсруулах	“Эрх зүйн шинэтгэл II” хөтөлбөрийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр II”-ийг боловсруулах ажлын хэсгийг ХЗДХС-ын тушаалаар байгуулсан. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох үүднээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан, хуулийн төслийн хамт ЗГХЭГ-т хүргүүлсэн.
1.11.	Хууль зүйн туслалцаа авах хүрээг өргөжүүлэх замаар хууль зүйн туслалцааны эрх зүйн орчныг сайжруулах	Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар эцэслэн баталсан.
1.12.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг сайжруулах	Шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХЗДХСайдын 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн А/30 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг хийж, төслийг

		Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				боловсруулан холбогдох яамд, байгууллагуудад хүргүүлж, санал авахад бэлэн болсон.
1.13.	Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ хязгаарыг тодорхой болгох, Хууль тогтоомжийн тухай хуулийг боловсронгуй болгох	Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.
1.14.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хуулийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Түүнчлэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн.
1.15.	Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	7	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн албан бичгийн дагуу Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд 2019 оны 04 сарын 03-ны өдрийн 1-1/1437 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу тус хуулийн төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах албан хаагчийн нэрийг хүргүүлээд байна.
1.16.	Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж	0	1	Улсын төсөв	Хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.

		Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				
1.17.	Цахим шинэчлэлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулах	Шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	3	Улсын төсөв	Цахим гарын үсэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
1.18.	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах	Шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	8	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилтийн үр дагавар, гадаад улс, орнуудын харьцуулсан судалгаа болон хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн. Хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Улсын Их Хурлаас хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсантай холбогдуулан хууль санаачлагч өөрчлөгдсөн тул ХЗДХЯ-ны тухайд дээрх хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, хуулийн төслийг боловсруулж байна.
Зорилт 2. Хоёр ба олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						
2.1.	Гадаад орнуудтай эрүү, иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн орчныг өргөжүүлэн хөгжүүлэх	Олон талт болон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их	36	41	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	-Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын Конвенцийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. -"Иргэний ба худалдааны хэргийн талаар эрх зүйн болон шүүхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард

		Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”, “Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээ”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хооронд гэрээ” зэрэг хоёр талт олон улсын гэрээ, хэлэлцээрийг эцэслэн боловсруулж, гарын үсэг зурахад бэлэн болгов.
2.2.	Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Монгол Улс нэгдэн орсон хүний эрхийн чиглэлээрх конвенцид заасан Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилтийн судалгаа хийх	Судалгааны тайланг хэлэлцүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/101 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсгээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Засгийн газрын тайлангийн төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. -Эрүүдэн шүүхийн эсрэг асуудлыг хариуцсан Хорооноос Монгол Улсын Засгийн газрын 3 дахь удаагийн ээлжит тайланг хэлэлцэх товыг хүлээж байна.
2.3.	Засгийн газарт холбогдох олон улсын арбитрын маргаанд Засгийн газрыг төлөөлж оролцох зохион байгуулалтын бүтцийн нэгжийг бий болгох	Арбитрын маргаан хариуцсан нэгж байгуулагдсан эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газарт Арбитрын маргаан хариуцсан нэгж байгуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд яамдуудаас санал авахаар хүргүүлээд байна.
2.4.	Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх	Арга хэмжээ зохион байгуулсан эсэх, баримт бичиг байгуулсан эсэх	0	4	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	-Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар тэргүүтэй төлөөлөгчдийн 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 26-ны өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн ажлын айлчлалыг зохион байгуулж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Хессен муж улсын Хууль зүйн яам болон Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулав.

						Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын Америкийн Нэгдсэн Улсад 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 10-ны өдрүүдэд томилолтоор ажилласан холбогдох арга хэмжээг зохион байгуулав. -Тус яамны харьяа агентлаг, байгууллагуудын гадаад улсын ижил түвшний байгууллагатай байгуулах санамж бичиг, гэрээг хянаж, Гадаад харилцааны яамнаас зөвшөөрөл авч уламжилж ажиллав.
2.5.	Олон улсын байгууллагын болон гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн төсөл, хөтөлбөрийн санал хүргүүлэх, хэрэгжүүлэх, уялдааг хангах	Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдааг хангаж, Сангийн яам болон холбогдох олон улсын байгууллага, гадаад улсаас санал, зөвшөөрөл авсан эсэх	7	9	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	-БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Эрх зүйн шинэтгэл багц төсөл"-ийн хүрээнд "Хууль сахиулахын их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн төв байрны сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт", 2,0 сая ам.доллар: БНСУ-ын "АйКрафт Консорциум" ХХК тус төслийн гүйцэтгэгчээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгосон. Төслийн хүрээнд 30.000 ам.долларын өртөг бүхий тоног төхөөрөмжийг ДХИС-д хүлээлгэж өгсөн ба төсөл хэрэгжиж дууссан эцсийн тайланг Эксим банк, холбогдох байгууллагууд болон Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн тус төслийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлэх саналыг Англи, Монгол хэл дээр боловсруулж, мөн Сангийн яаманд хүргүүлээд байна. -“Архивын ерөнхий газрын шинэ цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт”, 19,0 сая ам.доллар: Төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтийг БНСУ-ын Эксим банканд хүргүүлж, зөвшөөрөл авснаар Ди Би Консорциумтай гэрээ байгуулсан. Ди Би Консорциумаас ирүүлсэн баримтад үндэслэн урьдчилгаа төлбөрийн хүсэлтийг Сангийн яаманд, холбогдох баримт бичгийг БНСУ-ын Эксим банкинд тухай бүр хүргүүлж, тус банкны зөвшөөрлийг авахаар ажиллаж байна.

						-ШШҮХ-ийн “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах” төсөл, 18.5 сая ам.доллар: Зээлийн хэлэлцээрийг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Тендерийн баримт бичгийг хамтран боловсруулж байгаа бөгөөд тендерт оролцох компаниудын богино жагсаалтыг үүсгэхээр нэр бүхий 5 компанид хүргүүлсний дагуу тендерт оролцох компаниуд сонирхлоо илэрхийлж холбогдох материалыг ирүүлсэн. Энэ хүрээнд сонирхлоо илэрхийлэх загвар хуудас, компаниудыг шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тус бүр Эксим банк руу илгээж зөвшөөрөл авсан. -Төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын богино долгионы радио станцуудыг шинэчлэх, нийслэл, орон нутгийн авто зам, уулзвар, гарц, хяналтын цэгүүдэд дэвшилтэт технологи бүхий теле хяналтын камер суурилуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нэгдсэн удирдлага бүхий хяналтын ухаалаг систем нэвтрүүлэх чиглэлээр судалгаа гаргах, төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог тодорхойлоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн хурлуудыг зохион байгуулав.
Зорилт 3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
3.1.	Аутсорсингийг дэмжих бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах	Боловсруулсан хөтөлбөрийн тоо	0	2	Улсын төсөв	-Шинжилгээний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системийн бодлогын даалгаврыг шинэчлэн боловсруулсан.
3.2.	Цахим засаг, төрийн энтерпрайз архитектур болон салбарын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх бодлогын хувилбар боловсруулах, хэрэгжүүлэх	Боловсруулсан бодлогын хувилбарын тоо	0	2	Улсын төсөв	-“Зөрчлийн бүртгэлийн нэгдсэн систем”-ийг боловсруулсан бөгөөд тус системийг Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс нэвтрүүлэхээр туршилт хийж байна. Тус системээр дамжуулан зөрчил шалган шийдвэрлэх,

	ажлыг зохион байгуулах, зохицуулах					хянах эрх бүхий 32 байгууллагын 12000 гаруй албан хаагч суурин болон зөөврийн төхөөрөмж ашиглан холбогдож, үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр явуулах юм. -Улсын бүртгэлийн ерөнхий газрын хаалттай болон хязгаартай цахим мэдээллийн сангийн хяналт, мониторингийн нэгдсэн системийг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.
3.3.	Салбарын байгууллагуудын өгөгдлийн сан, мэдээллийн системийг нэгдсэн энтерпрайз архитектурын дагуу хөгжүүлэх, нээлттэй өгөгдлийг нэвтрүүлэх, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын тоо	0	13	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн яам “Ньюсоник” ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 06-ны ХЗДХЯ/20220003 тоот “ХЗДХ-ийн салбарын цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем” /eDOC систем/ худалдан авах гэрээг байгуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тус салбарын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 4213 хэрэглэгч eDoc системд бүртгэгдэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын /docx.gov.mn/ системээр дамжуулан тоон гарын үсгээр баталгаажуулан албан бичгээ солилцож байна. Энэхүү системийн сургалтад тус яамны болон харьяа агентлаг, байгууллагын нийт 120 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан.
3.4.	Яамны мэдээллийн технологийн талаар баримтлах нэгдсэн бодлого чиглэл, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөө боловсруулсан эсэх	0	1	Улсын төсөв	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/77 дугаар тушаалаар цахимын багц хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, салбар хоорондын уялдаа, холбоог хангах, бусад салбарын цахим шилжилтийн бодлого, стратеги төлөвлөгөө, мэдээллийн технологийн төслийн төлөвлөлтөд дэмжлэг үзүүлж, зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий бодлогын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнд тус яамны Мэдээллийн технологийн газрын дарга ажиллаж байна.

Зорилт 4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, зохион байгуулах замаар санхүүгийн сахилга батыг сайжруулна.

4.1.	Салбарын урт болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Боловсруулсан төлөвлөгөөний тоо	1	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн 5 судалгааг гаргаж, Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгаад байна.
4.2.	Салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, салбарын хэмжээнд санхүү бүртгэлийн сахилга батыг хангуулах ажлыг зохион байгуулах	Боловсруулсан бодлогын баримт бичгийн тоо	1	1	Улсын төсөв	"Хууль зүй, дотоод хэргийн салбарын санхүүгийн нэгдсэн удирдлагын программ"-ыг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан салбарын "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн А/261 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 9 дүгээр сарын 20-ны өдөр анхны хурал хийж, Хууль зүй, дотоод хэргийн салбарын "Санхүүгийн нэгдсэн удирдлагын систем"-тэй холбоотой нэгтгэсэн хөрөнгө, материалын зүйлийн жагсаалтыг хэлэлцэж баримт бичгийг боловсруулсан.
	Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн программ хангамжийг боловсруулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын цахим санхүү бүртгэлийн жишиг салбар болох	Зохион байгуулсан ажлын тоо	0	8	Улсын төсөв	Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн программ хангамжийг боловсруулсан бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн ХЗДХЯ-ны харьяа 20 байгууллагад туршилтаар нэвтрүүлэн ажиллаж байна. Туршилтын хугацаанд дээрх байгууллагууд харилцагчийн мэдээлэл, мөнгөн хөрөнгийн бүртгэл, өглөг авлагын бүртгэл, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг оруулан санхүүгийн тайланг бэлтгэх ажил хийгдэж байна.
		Боловсруулсан программ хангамжийн тоо	0	1		Хууль зүй, дотоод хэргийн салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг боловсруулж, нэвтрүүлсэн бөгөөд туршилт хийж байна.

ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН НЭР НЭГ. ХЭРЭГЖҮҮЛЭХ						
ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР Хоёр. Хэрэгжүүлэх зохион байгуулах						
Зорилт 1. Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх зорилтын хүрээнд						
1.1.	Хууль тогтоомж болон салбарын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ талаар холбогдох бусад байгууллага, орон нутгийн хууль зүйн албадын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд ийг хамруулан зохион байгуулсан сургалтын тоо	0	4	Улсын төсөв	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, мэргэжилтэн нарт зориулсан сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 30-наас мөн оны 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав.
1.2.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын стратегийг тодорхойлж, хэрэгжилтийг зохицуулан, нэгдсэн удирдлагаар хангах	Стратеги төлөвлөгөө боловсруулсан эсэх	0	1	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/150 дугаар тушаалын хавсралтаар харьяа агентлаг, байгууллагуудын "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
1.3.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	-	-	Улсын төсөв	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 634 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгсөн байна.
1.4.	Хуульч, өмгөөлөгч, нотариатчийн өөрөө удирдах ёсны байгууллагыг арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах	Зохион байгуулсан ажлын тоо	0	1	Улсын төсөв	-Хуульч, өмгөөлөгч, нотариатчийн өөрөө удирдах ёсны байгууллагыг арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах хүрээнд Монголын нотариатын танхимын дэргэдэх "Сахилгын зөвлөл"-ийн 18 удаагийн хуралдаанд оролцож, 29 тогтоол, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны "Мэргэжлийн хариуцлагын хороо"-ны 20 удаагийн хуралдаанд

					оролцож 43 тогтоол тус тус гарган шийдвэрлэхэд оролцсон. -Монголын Нотариатчидын танхимын дэргэдэх “Сахилгын зөвлөлийн ажиллах журмын төсөл боловсруулсан бөгөөд сахилгын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар журмын төслийг танилцуулж байна. -Нотариатын үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулах /зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болгох/ нийт 74 тушаал боловсруулж батлуулав. -Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Нотариатчийн мэргэшлийн шалгалт зохион байгуулах тухай” 2022 оны А/100 дугаар тушаал, мөн сайдын “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2022 оны А/106 дугаар тушаалын дагуу 2022 оны 06 дугаар сарын 13-наас 18-ны өдрүүдэд нотариатчийн мэргэшлийн шалгалт зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 9 хуульчид нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон. Мөн 2022 онд нотариатын нөөцөд бүртгэлтэй байсан 9 хуульчид нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон байна.
1.5.	Хуульд заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой бодлогын хэрэгжилтийг хангах, харьяа агентлаг, байгууллагад дэмжлэг үзүүлэх	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	-	-	Улсын төсөв Тайлант хугацаанд дараах хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн. Үүнд -Тамга, тэмдэг үйлдвэрлэх 4 тусгай зөвшөөрөл олгож, 3 зөвшөөрлийг сунгаж, тусгай зөвшөөрөл хүссэн 3 хүсэлтийг хуульд заасан бүрдэл хангаагүй үндэслэлээр буцаасан; -Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах адилтгах хэрэгслийг нийтэд худалдах, импортлох 7 тусгай

						зөвшөөрлийг сунгаж, 3 зөвшөөрлийг хүчингүй болгосон; -Сум үйлдвэрлэх 2 тусгай зөвшөөрөл олгосон; -Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх 1 тусгай зөвшөөрөл олгосон.
1.6.	Харьяа агентлаг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулах, биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо	0	12	Улсын төсөв	-Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Гадаадын иргэн харьяатын газар, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Оюуны өмчийн газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төвийн дарга нарын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг эцэслэн хянаж, ХЗДХС-аар батлуулж, холбогдох харьяа агентлаг, байгууллагуудад 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр хүргүүлж ажилласан.
Гурав.Хянан үнэлэх						
Зорилт 1. Бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх замаар удирдлагыг мэдээллээр ханган эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлнэ.						
1.1.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журам, аргачлал боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Журам, аргачлал боловсруулсан эсэх	0	2	Улсын төсөв	Салбарын “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж, ХЗДХС-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/107 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллав. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/224 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав.
	1.2.Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр,	Хяналт-шинжилгээ,		4	Улсын төсөв	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн

	төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах	үнэлгээ хийсэн ажлын тайлан /нэгдсэн тоо, жилээр/	1			хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, ЗГХЭГ-т тухай бүр тайлагнан ажиллав. Мөн Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д нэмэлт өөрчлөлт орсны дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагаан хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг цахим сангаар сар бүр тайлагнан ажиллав.
		Хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн хэрэглэгчийн үнэлгээний тайлан	1	4		Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.6-д "... захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно" гэсний дагуу агентлаг, байгууллагууд хэрэглэгчийн үнэлгээг хийлгэв.
1.3.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Дотоод аудит хийсэн тайлан	3	12	Улсын төсөв	"Дотоод аудитын чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын жилийн төлөвлөгөө"-г Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Тус ажлын хүрээнд 2021 онд 8 удаа, 2022 онд 3 удаа дотоод аудит хийж, үр дүнг удирдлагуудад танилцуулан ажиллав.

	1.4.Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх	Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээний тайлан	1	4	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/224 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулж, батлуулсан. Дээрх аргачлалын дагуу жил бүр салбарын эрсдэлийн үнэлгээг хийж, удирдлагуудад танилцуулан ажиллав.
		Салбарын төвлөрсөн бус статистик мэдээлэл /сар бүр/	12	48		Хууль зүй, дотоод хэргийн салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг сар бүрийн 10-ны дотор буюу нийт 24 удаа гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
1.5.	Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх	Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дагаварт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх	0	1	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтийн үр нөлөөнд үнэлгээ хийх” ажлыг 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс 2022 оны 2 дугаар сарын 7-ны өдрүүдэд хийж, удирдлагуудад танилцуулав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 1/1162 дугаартай албан даалгаврыг хүргүүлсэн ба уг албан даалгаврын 5 дугаарт заасны дагуу Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийн байдлыг сар бүр удирдлагуудад танилцуулан ажиллаж байна.
Дөрөв.Идэвхижүүлэх, дэмжих						
Зорилт 1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулна.						
1.1.	Төрийн захиргаа, хүний нөөцийн манлайллыг хангах, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн	Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн	1	4	Улсын төсөв	-Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хамааран хэрэгжүүлэх арга

	биелэлтийг хангах, яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хяналт тавьж тайлагнах	биелэлтийн тайлан /жилээр/				хэмжээний 2022 оны хэрэгжилтийн нэгдсэн тайлан болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 5 жилийн үндсэн чиглэлийг холбогдох журамд заасан хугацаанд гаргаж, unelgee.gov.mn цахим системээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. -Монгол Улсын Ерөнхий сайдын шуурхай 20 үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, Засгийн газрын unelgee.gov.mn цахим системээр долоо хоног бүр нийт 4 удаа тайлагнаж ажилласан. -Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэлийн YII.5 дахь хэсгийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хууль зүй, дотоод хэргийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хууль зүй, дотоод хэргийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хууль зүй, дотоод хэргийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хууль зүй, дотоод хэргийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г тус тус боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А\110 дугаар тушаалаар батлуулан, харьяа агентлаг, байгууллагуудад тус тус хэрэгжүүлэхээр хүргүүлж ажиллав.
	Яамны гүйцэтгэлийн		1	4		Тус яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг загвар, журмын дагуу боловсруулж, төсвийн шууд захирагчаар журамд заасан хугацаанд батлуулав.

		төлөвлөгөөний тоо				
1.2.	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	-	100	Улсын төсөв	-Able /https://intranet.mojha.gov.mn/ программд бүртгэгдсэн иргэд, байгууллагаас ирүүлсэн нийт 61552 өргөдөл гомдол, санал хүсэлтийн 58932 буюу 95,4 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна. -Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж, цохолт хийгдсэний дараа холбогдох газар, хэлтсийн дотоод ажил хариуцсан мэргэжилтэнд цахимаар шилжүүлж, эх хувийг бичиг хэрэгт төвлөрүүлэн хадгалж, шийдвэрлэлтийн байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна.
1.3.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах	ХАСУМ цахимаар мэдүүлсэн албан хаагчийн тоо	109	436	Улсын төсөв	-“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн тус яаманд хамаарах заалтын хүрээнд 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. -Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, эхний хагас жилийн тайланг 2022 оны 07 дугаар сарын 01-ний дотор, жилийн эцсийн тайланг 2023 оны 01 дүгээр сард Авлигатай тэмцэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.
1.4.	Салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	Баримт бичиг боловсруулсан эсэх	0	1	Улсын төсөв	-Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 сарын 16-ны өдрийн А/122 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав.
1.5.	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах	Төлөвлөгөөг батлуулсан эсэх	0	1	Улсын төсөв	Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлэн Засгийн газрын Хэрэг эрхэлх газарт тайлагнаж ажиллав. Үүнд: -2012-2022 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт;

						- Хүний эрхийн үндэсний форум-2021"-ээс гаргасан зөвлөмжөөс Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зөвлөмжийн хэрэгжилт; -Хүний эрх, жендэр, ардчилал, оролцоо, засаглал, байгаль орчны чиглэлээр 2018-2022 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөний биелэлт; -2023-2025 онд энэ чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэрэг болно. Мөн 2003-2022 оны хэрэгжилтийн тайланг 2022 оны 07 дугаар сард Сургалт, судалгаа, пиар, мониторингийн стратеги академид хүргүүлэн ажиллав.
1.6.	Аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах, үр дүнг нь тооцох ажлыг зохион байгуулах, зохицуулах	Гэрээний тоо	22	88	Улсын төсөв	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх нь” нэгдсэн зөвлөгөөнийг 2022 оны 02 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтын үеэр Хууль зүй, дотоод хэргийн Сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.
1.7.	Эрх зүйн сургалт, сурталчилгааны талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулах	Төлөвлөгөө боловсруулсан эсэх	0	1	Улсын төсөв	“Хууль зүй, дотоод хэргийн яамны Эрх зүйн сургалт, сурталчилгааны 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргын батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав.
1.8.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Төлөвлөгөө боловсруулсан эсэх	0	1	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагуудын 2022 онд хэвлэл мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Дэд сайдаар батлуулсан. Тус төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 3/761 тоот албан бичгээр

						харьяа агентлаг, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллав.
		ХМХ-тэй харилцах ажлыг зохион байгуулсан эсэх	0	1		Тус ажлын хүрээнд харьяа агентлаг, байгууллагууд давхардсан тоогоор 432 хэвлэл мэдээллийн хэрэгслээр 640 удаагийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг хамтран хийж гүйцэтгэсэн. Мөн Засгийн газрын хэвлэл мэдээллийн газар, Цахим хөгжлийн яамтай хамтран Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 18 удаагийн шууд бичлэг, 21 видео ярилцлагыг тус яамны фэйсбүүк пэйж хуудаст байршуулж олон нийтэд хүргэсэн.
1.9.	Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр, яамны зүгээс бусад байгууллагатай байгуулах гэрээний эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах	Эрх зүйн үндэслэл хангагдсан эсэх	0	1	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас иргэн, хуулийн этгээдтэй 2022 онд нийт 95 гэрээний төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, гэрээний дугаар олгосон. Мөн энэ хүрээнд шаардлагатай зөвлөгөө, мэдээллийг өгч хамтран ажиллав.
Зорилт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, зохион байгуулах замаар санхүүгийн сахилга батыг сайжруулна.						
2.1.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах	Төсвийн гүйцэтгэлийн хувь	95	99.2	Улсын төсөв	-Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалт, 31 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч /Хууль зүй, дотоод хэргийн сайд/-ийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн саналыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн, хянан боловсруулж, төслийн тоон мэдээллийг төсвийн төлөвлөлтийн “Fiscal-B”, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн “PIMIS” цахим системийн програмд шивж, танилцуулгыг холбогдох материалын хамт Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 1/4192 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

						-Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад 41.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлын төсвийг баталсан. -Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан 56 хөрөнгө оруулалтын багц төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянан баталгаажуулж жилийн эцсийн байдлаар 62 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.
2.2.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувь	94.5	99.2	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/265 тоот албан бичгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жилийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн. Тендерийн үр дүн, гэрээний мэдээллийг tender.gov.mn-д цахимаар оруулах ажлын гүйцэтгэтийг тухай бүр хяналт тавьж ажиллав.
2.3.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн өмчийн бүртгэлд, хяналт тавих, тайлагнах	Саналын шийдвэрлэлтийн хувь	98.8	100	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын харьяа 14 агентлаг, байгууллагаас ирүүлсэн 5,503.9 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 5,112.3 сая төгрөгийг хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох, 43,812.2 сая төгрөгийг хөрөнгийг шилжүүлэх, 11,310.8 сая төгрөгийг хөрөнгийг бүртгэх нийт 47 саналыг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу судлан, холбогдох баримтын бүрдлийг хянаж, зөвшөөрөл авах тухай албан бичгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн.
2.4.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх	Алдаа, зөрчлийн тоо	64	48	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын хотын хүрээний 51 нэгж урсгал болон хөрөнгө

						оруулалтын 110 дансны, 26758 ширхэг төлбөрийн хүсэлтээр 494,1 тэрбум төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 5 дугаар сараас төрийн тусгай алба буюу ЦЕГ, ШШГЕГ, ДХИС, ТТАХНЭ, байгууллагыг ТАЦНС-д холбох ажлыг сангийн яам, төрийн албаны зөвлөлтэй хамтран бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Алдаа зөрчлийн 48 тохиолдлыг тухай бүр шалгаж залруулсан.
2.5.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал	Зөрчил, акт, албан шаардлагын тоо	103	90	Улсын төсөв	"Хууль зүй, дотоод хэргийн салбарын санхүүгийн нэгдсэн удирдлагын программ"-ыг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан салбарын "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн А/261 тоот тушаалаар байгуулсан. Мөн зөрчил, албан шаардлагын 90 тохиолдлыг залруулга хийлгэн баланс тусгасан.
2.6.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	93	99.2	Улсын төсөв	-Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу 2023 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн төсвийн саналыг харьяа агентлаг, байгууллагуудаас авч нэгтгэн 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 1/4192 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. -“Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2017-2020 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Засгийн газар хоорондын Ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд “Архивын ерөнхий газрын шинэ цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэн, төслийн гүйцэтгэгчээр шалгарсан Ди Би Консорциумтай 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Үүнтэй холбоотойгоор Сангийн сайдын 2022 оны 90 дүгээр тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц байгуулагдсан

						бөгөөд тус төслийн нэгжид 2022 онд нийт 116,9 сая төгрөгний төсөв батлагдсан. -БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх санал ирүүлсэн байгууллагуудын баримт бичигт үнэлгээ хийн, хураангуй жагсаалтыг үүсгэн, үнэлгээний тайлан боловсруулсан. Тус төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг (Ажлын даалгавар, өгөгдлийн хүснэгт, гэрээний тусгай нөхцөл)-ийн төсөлд БНСУ-ын Эксим банк, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн болон үнэлгээний хорооны гишүүдээс ирүүлсэн саналуудыг нэгтгэн боловсруулж БНСУ-ын Эксим банкинд хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу 2023 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн төсвийн саналыг харьяа агентлаг, байгууллагуудаас авч нэгтгэн 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 1/4192 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
2.7.	Салбарын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Баригдсан орон сууцны тоо	773	840	Улсын төсөв	Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсан дахь “Хуулийн байгууллагын ажилтан албан хаагчдын орон сууцны цогцолбор хороолол” төслийн хүрээнд 2021 онд 118 айлын орон сууцыг ашиглалтад оруулан хүлээлгэж өгсөн. Үргэлжлүүлэн тус онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байсан 118 айлын орон сууц цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хугацаандаа ороогүй хойшлогдсон ч ашиглалтад оруулахаар хяналт тавин ажиллаж байна.

		Дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо	21	24		Мөн 59 албан хаагчид байрны квот олгосон.
2.8.	Яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах	Алдаа, зөрчлийн тоо	1	0	Улсын төсөв	Тус яамны барилга байгууламж, албан хаагчдын өрөө тасалгааны хэвийн үйл ажиллагаа, тав тухтай орчин нөхцлийг хангах зорилгоор барилгын цонх, граж, өрөө тасалгаанд шалгалт хийж 4 зөрчлийг илрүүлсэн. Үүнтэй холбогдуулан яамны барилгын ажил гүйцэтгэгч “Хурд групп” ХХК-иар барилгын баталгаат хугацаанд хийгдэх засварыг жагсаалтын дагуу 2022 оны 08 дугаар сарын 01-нээс 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгүүлсэн.

---oOo---